



“СЭТГЭЛ СУДЛААЧ МЭРГЭЖЛИЙН ҮНЭ ЦЭНЭ” V ОЛИМПИАД



БАТЛАВ: НССДС-ИЙН ЗАХИРАЛ

Ч.БАЗАР

Др. Ч.БАЗАР

**СЭТГЭЛ СУДЛАЛЫН УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР Д.САНЖЖАВЫН НЭРЭМЖИТ
“СЭТГЭЛ СУДЛААЧ МЭРГЭЖЛИЙН ҮНЭ ЦЭНЭ” V ОЛИМПИАДЫН
УДИРДАМЖ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1994 онд Сэтгэл судлаач мэргэжлээр үндэсний мэргэжилтэн бэлтгэснээс хойш тасралтгүй 26 жил Сэтгэл судлал хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэн төгсгөж байгаа Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль Монголын сэтгэл судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүднээс энэхүү мэргэжлээр суралцаж буй оюутан суралцагчдын дунд Доктор , профессор Д.Санжжавын нэрэмжит “Сэтгэл судлаач мэргэжлийн үнэ цэнэ” олимпиадыг 5 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж байна.

ХОЁР. ОЛИМПИАДЫН ЗОРИЛГО

Орчин цагт хүмүүс амьдралын хэв маяг, хэвшмэл үйлдлээсээ шалтгаалж стресст өртөх хандлага нэмэгдсэн. Мөн цар тахалтай холбоотой хөл хорионы үеэр хүмүүсийн амьдралын хэв маяг алдагдаж сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод гээд олон янзын шалтгааны улмаас стресст өртөж байна. Стрессээс үүдэлтэй олон сөрөг үзэгдэл нийгэмд бий болж байгаагаас дурьдвал, архи, тамхи, мансуурлах бодисын донтолт, хүчирхийлэл, амиа хорлолт гэх мэт эрсдэлт зан үйлүүд үйлдэгдсээр байна. Эндээс дүгнэхэд, стресс нь нийгмийн сэтгэл зүйн тулгамдсан асуудал болж байна. Стрессээс үүдэлтэй архидалт, бие махбодийн болон сэтгэл санааны хүчирхийлэлд янз бүрийн насныхан өртөж байгаа бөгөөд стресст өртөгч нь өөртөө болон нийгэмд аюултай эрсдэлт зан үйл хийх хор уршигтай. Иймд стрессээс үүдэлтэй хор уршгийг сэтгэл зүйн шинжлэх ухааны онолд тулгуурлан шинжилж, нийгмийн стресс үүсгэгчийг судлан илрүүлж, урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн үүднээс асуудлыг шийдвэрлэх гарц гаргалгааг дэвшүүлэхэд Сэтгэл судлал хөтөлбөрөөр суралцаж буй оюутан залуусын анхаарал, оролцоог хандуулах нь нийгмийн хариуцлага болон тулгарч байна.

Иймд Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн энэ удаагийн олимпиад нь нийгмийн стресс, бухимдал түүнээс гарах үр дагаварыг олон талаас нь судлах, нийгэмд үүсээд буй стрессийг сэтгэл зүйн талаас нь шийдвэрлэх шийдлийг тодорхойлох, нийгмийн стресс бухимдлыг багасгахын тулд сэтгэл зүйчийн оролцоог идэвхижүүлэх, Сэтгэл судлаач мэргэжилтэн болохоор зорьж буй оюутан-судлаачдын мэдлэг, чадвар, судалгаа шинжилгээний ажлыг хөхүүлэн дэмжих, сэтгэл судлаачдын нэгдмэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгыг агуулж байна

ГУРАВ. БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Олимпиад хоёр үе шаттай зохион байгуулагдана.

Нэгдүгээр шат: “ Нийгмийн стресс ба сэтгэл зүйн үүднээс шийдвэрлэх арга зам” сэдвийн хүрээнд эсээ бичнэ. Үгийн тоо 2000-2500.

Эсээ бичих хугацаа: 2020 оны 10 дугаар сарын 26-наас 11 дүгээр сарын 17 хүртэл



Материалыг хүлээж авах өдөр: 2020 оны 11 дүгээр сарын 17

Хоёрдугаар шат: Ирсэн бүтээлүүдээс шилдэг 12 илтгэл шалгаруулж, 2020 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр хэлэлцүүлнэ.

ДӨРӨВ. ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нийтлэг шаардлага

1. Удирдсан багштай оролцоно.
2. Эрдэм шинжилгээний эсээний үндсэн загварын дагуу бичнэ.
3. Оюутны тодорхойлолт хавсаргана.
4. 2 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй багаар оролцож болно.

Тусгай шаардлага

1. Баримт нотолгоонд суурилсан байна.
2. Шийдлийн хувилбаруудыг боловсруулсан байна.

Техникийн шаардлага:

1. Илтгэл нь Windows Microsoft Office програм дээр (.docx) өргөтгөлтэй хийгдсэн байна.
2. Илтгэлийн ерөнхий гарчиг нь 14pt хэмжээтэй Bold, ТОМ ҮСГЭЭР, Дэд гарчгууд нь 12pt үсгийн хэмжээтэй Bold форматтай, Бичвэрийн үсгийн фонт-[Times new roman, 12pt, мөр хоорондын зай1, баруун зүүн талаасаа зэрэгцсэн байна]
3. Цаасны хэмжээ: Top:2.5 см, Bottom:2 см, Left:3 см, Right:2см
4. Ишлэл, эх сурвалж, ном зүйн бичилтийг олон улсын APA форматын дагуу бичнэ.

ТАВ. ШАГНАЛЫН САН

ТЭРГҮҮН БАЙР- 1 илтгэл, (Цом, Өргөмжлөл, 100 000 төгрөг)

ДЭД БАЙР- 1 илтгэл (Өргөмжлөл, 75 000 төгрөг)

ТУСГАЙ БАЙР- 1 илтгэл (Өргөмжлөл, 50 000 төгрөг)

Эрдэм шинжилгээний эсээг Munkhjin8890@gmail.com хаягаар 2020 оны 11 дугаар сарын 16-ны дотор илгээх ба Subject хэсэгт оролцогч өөрийн нэр, хаяг, утасны дугаараа тодорхой бичнэ.

Нэмэлт мэдээллийг дараах утсанд холбогдож авна уу.

Холбоо барих утас 99122956, 89122956

НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ

СЭТГЭЛ СУДЛАЛ, НИЙГМИЙН АЖЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ХОРОО

2020.10.26